

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: НТАГ-2026/002/НА-СТА-ТӨҮГ

Цахим хуудас: www.audit.mn	Санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер: Х.Түвшинбаяр Утас: 315558 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn
Улаанбаатар хот 2026 он	Аудитын менежер: Д.Отгонбаяр Утас: 325093 Цахим хаяг: otgonbayard@audit.gov.mn
	Ахлах аудитор: М.Ундармаа Утас: 325093 Цахим хаяг: undarmaam@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	10
4. АУДИТЫН ТАЙЛАН	14
4.1 Ерөнхий зүйл	15
4.2 Материаллаг байдал	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	17
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	21

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон улсын стандарт
БНХАУ	Бүгд найрамдах хятад ард улс
ДБ	Дэлхийн банк
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТЗБАХ	Техник зохион байгуулалтын арга хэмжээ
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
УБДС	Улаанбаатар дулааны сүлжээ
ХАА	Худалдан авах ажиллагаа
ХАБ	Хөдөлмөрийн аюулгүй байдал
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЦЭХ	Цахилгаан эрчим хүч

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2026.03.15 № 507
танай _____-ны № _____-т

БАГАНУУР ЗҮҮН ӨМНӨД БҮСИЙН
ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ
ТӨХК-ИЙН ЗАХИРАЛ
Х.ГАНЧУЛУУН ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудыг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлг тэмдэглэсэн хэсэг

Цахилгаан хангах, түгээх үйл ажиллагааны зардалд нийт 29 нэр төрлийн 49,309.8 сая төгрөгийн зардал төлөвлөснөөс гүйцэтгэлээр 29 нэр төрлийн 46,658.8 сая төгрөгийг зарцуулж, 2,651.0 сая төгрөг хэмнэсэн байна.

Эрчим хүчний Сайдын 2025 оны А/249 дүгээр тушаалаар их засвар, техник зохион байгуулалтын арга хэмжээ, хөрөнгө оруулалтын нийт 120 нэр төрлийн 7,170.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг хийж гүйцэтгэхээр батлагдсанаас нийт 120 нэр төрлийн ажлыг 6,622.9 сая төгрөгөөр 100 хувь гүйцэтгэж, төлөвлөгөөнөөс 7.6 хувиар буюу 547.6 сая төгрөгийн хэмнэлт бий болгосон байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд тус компани нь нийт 256,323.0 сая төгрөгийн орлого бүрдүүлж, үйл ажиллагаандаа 263,901.1 сая төгрөгийг зарцуулснаар татварын өмнөх 7,578.1 сая төгрөгийн, татварын дараах 7,301.7 сая төгрөгийн алдагдалтай ажиллаж, төлөвлөгөөт алдагдлын хэмжээ 7,312.5 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Зардал нэмэгдэж, алдагдал өссөн нь Эрчим хүчний зохицуулах хорооны 2025 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 648 дугаар тогтоолоор худалдан авах цахилгаан эрчим хүчний тарифыг 268.95 төг/кВт.цаг байсныг 39.08 төг/кВт.цагаар нэмэгдүүлж 308.03 төг/кВт.цаг болгосонтой холбоотой худалдан авах цахилгаан эрчим хүчний зардал 8.9 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь шууд нөлөөлсөн байна.

Бусад асуудал

Эрчим хүчний Сайдын 2025 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн А/21 дүгээр тушаал, 2025 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн А/249 дүгээр тушаалуудаар баталсан компанийн 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөний 12 үзүүлэлтүүдээс 12 үзүүлэлтийг хангаж ажилласан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	3,176,860,261.16	1,895,652,063.99
1.1.2	Дансны авлага	2,685,992,102.44	1,407,725,552.36
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	22,298,407.26	1,543,893,734.87
1.1.4	Бусад авлага	15,591,900.66	48,956,988.09
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6	Бараа материал	2,331,090,605.81	2,152,018,762.27
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	6,877,669.82	7,700,701.57
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө		
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	8,238,710,947.15	7,055,947,803.15
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	174,851,486,513.58	175,830,391,353.28
1.2.2	Биет бус хөрөнгө	4,014,784,407.09	3,669,653,912.52
1.2.3	Биологийн хөрөнгө		
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт		
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө		
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	395,302,575.90	554,388,874.10
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө		
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө		
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	179,261,573,496.57	180,054,434,139.90
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	187,500,284,443.72	187,110,381,943.05
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	3,002,552,315.60	5,029,920,905.40
2.1.1.2	Цалингийн өглөг		
2.1.1.3	Татварын өр	706,249,853.39	2,123,370.00
2.1.1.4	НДШ - ийн өглөг		
2.1.1.5	Богино хугацаат зээл		
2.1.1.6	Хүүгийн өглөг	207,675,288.43	264,891,607.52
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг		
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	497,468,542.89	963,380,223.25
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/		
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр		9,494,167.00
2.1.12	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)-д хамаарах өр төлбөр		
2.1.1.12	Урт хугацаат өрийн тайлант үеийн өглөг	3,448,685,706.06	6,983,054,681.54
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	7,862,631,706.37	13,252,864,954.71
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл		
2.1.2.1	Урт хугацаат зээл	36,438,369,744.92	34,305,199,126.52
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/		
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/		
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр		
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	5,695,279,254.75	5,578,001,942.81
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр		

Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

2.1.2.5			
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	42,133,648,999.67	39,883,201,069.33
2.2	Өр төлбөрийн нийт дүн	49,996,280,706.04	53,136,066,024.04
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч: - төрийн	62,531,339,800.00	65,633,550,600.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	71,986,566,050.58	71,963,501,851.70
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	5,093,428,804.03	5,819,627,926.44
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(2,107,330,916.93)	(9,442,364,459.13)
2.3.10			
2.3.11	Эздийн өмчийн дүн	137,504,003,737.68	133,974,315,919.01
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	187,500,284,443.72	187,110,381,943.05

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12 сарын 31	2025 оны 12 сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	191,985,492,615.38	253,786,394,520.40
2	Борлуулалтын өртөг	185,180,628,505.48	252,132,430,156.84
3	Нийт ашиг (алдагдал)	6,804,864,109.90	1,653,964,363.56
4	Түрээсийн орлого	41,494,164.63	62,355,567.77
5	Хүүгийн орлого	53,889,834.27	309,535,167.81
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого	1,320,032,539.34	1,784,062,387.05
9	Борлуулалт, маркетингийн зардал	5,865,543,233.48	6,726,293,156.18
10	Ерөнхий ба удирдлагын зардал	634,729,509.18	766,992,023.68
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал	903,056,220.77	2,339,781,836.33
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(162,089,803.73)	(1,602,616,457.82)
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(50,441,196.42)	47,659,348.35
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	604,420,684.56	(7,578,106,639.47)
19	Орлогын татварын зардал	306,863,595.83	(276,363,610.14)
20	Татварын дараах ашиг (алдагдал)	297,557,088.73	(7,301,743,029.33)
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	297,557,088.73	(7,301,743,029.33)

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2023 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	62,531,339,800.00	72,311,022,635.90	4,784,384,211.03	(2,658,008,420.37)	136,968,738,226.56
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				(227,036,385.61)	(227,036,385.61)
3	Залруулсан үлдэгдэл	62,531,339,800.00	72,311,022,635.90	4,784,384,211.03	(2,885,044,805.98)	136,741,701,840.95
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				297,557,088.73	297,557,088.73
5	Бусад дэлгэрэнгүй орлого			309,044,593.00		309,044,593.00
6	Өмчид гарсан өөрчлөлт		155,700,215.00			155,700,215.00
7	Зарласан ногдол ашиг					-
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		(480,156,800.32)		480,156,800.32	-
9	2024 оны 12 сарын 31-ны үлдэгдэл	62,531,339,800.00	71,986,566,050.58	5,093,428,804.03	(2,107,330,916.93)	137,504,003,737.68
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга			(3,294,000.00)	(56,354,711.75)	(59,648,711.75)
11	Залруулсан үлдэгдэл	62,531,339,800.00	71,986,566,050.58	5,090,134,804.03	(2,163,685,628.68)	137,444,355,025.93
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(7,301,743,029.33)	(7,301,743,029.33)
13	Бусад дэлгэрэнгүй орлого			3,831,703,922.41		3,831,703,922.41
14	Өмчид гарсан өөрчлөлт	3,102,210,800.00		(3,102,210,800.00)		
15	Зарласан ногдол ашиг					-
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		(23,064,198.88)		23,064,198.88	-
17	2025 оны 12 сарын 31-ны үлдэгдэл	65,633,550,600.00	71,963,501,851.70	5,819,627,926.44	(9,442,364,459.13)	133,974,315,919.01

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2024 оны 12 сарын 31	2025 оны 12 сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	158,944,222,869.34	227,096,658,223.42
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	156,091,665,525.91	223,658,645,704.59
	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	96,926,876.50	102,182,881.00
	Буцаан авсан албан татвар		
	Татаас, санхүүжилтийн орлого		
	Бусад мөнгөн орлого	2,755,630,466.93	3,335,829,637.83
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	152,030,200,361.96	224,522,875,120.80
	Ажиллагчдад төлсөн	18,566,634,619.28	22,010,606,114.21
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	5,192,785,378.30	6,338,463,400.48
	Бараа материал худалдан авахад төлсөн	117,938,299,878.07	181,117,260,762.95
	Ашиглалтын зардалд төлсөн	684,592,765.59	760,194,443.87
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	714,036,043.00	803,747,914.62
	Хүүгийн төлбөрт төлсөн	1,004,000,172.80	1,151,504,423.21
	Татварын байгууллагад төлсөн	4,233,599,055.32	7,509,576,992.81
	Даатгалын төлбөрт төлсөн		78,100,000.00
	Бусад мөнгөн зарлага	3,696,252,449.60	4,753,421,068.65
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	6,914,022,507.38	2,573,783,102.62
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	128,324,734.27	320,385,281.92
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	74,434,900.00	11,121,500.00
	Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		
	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		
	Хүлээн авсан хүүгийн орлого	53,889,834.27	309,263,781.92
	Хүлээн авсан ногдол ашиг		
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	2,467,971,679.08	4,174,302,875.65
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	2,467,971,679.08	4,174,302,875.65
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(2,339,646,944.81)	(3,853,917,593.73)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	3,323,356,022.50	3,015,326,160.93

Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	3,323,356,022.50	3,015,326,160.93
	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
	Төрөл бүрийн хандив		
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	8,492,415,488.56	3,016,399,866.99
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	8,492,415,488.56	3,016,399,866.99
	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		
	Төлсөн ногдол ашиг		
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(5,169,059,466.06)	(1,073,706.06)
	Валютын ханшийн зөрүү		
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(594,683,903.49)	(1,281,208,197.17)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	3,771,544,164.65	3,176,860,261.16
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,176,860,261.16	1,895,652,063.99

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

д/д	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Өмнөх оны мөн үе	2025 он				
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	дүн	хувь	
1	2	3	4	5	6	7	8	
1	1.1 Худалдан авсан цахилгаан	сая кВт*ц	686.7	772.3	787.7	15.4	102.0%	
	ДҮТ ТӨХХК-иас	сая кВт*ц	683.9	769.0	784.6	15.6	102.0%	
	Импортоор	сая кВт*ц	2.8	3.280	3.060	(0.2)	93.3%	
	1.2 Түгээлтийн нийт алдагдал	хувь	хувь	5.8%	5.45%	5.03%	-0.42%	92.5%
		сая кВт*ц	сая кВт*ц	39.7	42.1	39.7	(2.4)	94.3%
	ДҮТ ТӨХХК	хувь	хувь	5.7%	5.42%	5.03%	-0.39%	92.8%
		сая кВт*ц	сая кВт*ц	39.2	41.7	39.4	(2.2)	94.7%
	Импорт	хувь	хувь	17.4%	12.15%	8.04%	-3.75%	66.2%
		сая кВт*ц	сая кВт*ц	0.5	0.40	0.25	(0.15)	61.7%
	1.3 Борлуулсан ЦЭХ	сая кВт*ц	647	730.2	748.0	17.8	102.4%	
	үүнээс: ДҮТ ТӨХХК	сая кВт*ц	644.7	727.3	745.1	17.8	102.5%	
	Импорт	сая кВт*ц	2.3	2.9	2.8	(0.1)	97.7%	
Борлуулалтын үнэ дундаж	төг/кВт*ц	237.8	285.9	289.7	3.8	101.3%		
2 Нийт орлого	сая төг	194,010.7	247,455.2	256,323.0	8,867.8	103.6%		

Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

	Үүнээс: Борлуулалтын орлого	сая төг	153,285.9	207,945.3	215,860.3	7,915.0	103.8%	
	Түгээх үйлчилгээний орлого	сая төг	37,804.4	36,854.4	36,854.4	-	100.0%	
	Импортын ЦЭХ-ний орлого	сая төг	895.2	1,095.7	1,071.7	(24.1)	97.8%	
	Үйл ажиллагааны бус орлого	сая төг	2,025.2	1,559.7	2,536.6	976.9	162.6%	
	Нийт зардал	сая төг	193,406.3	247,443.2	263,901.1	16,457.9	106.7%	
3	Үүнээс: ХАЦЭХ-ний өртөг	сая төг	151,762.9	195,490.0	212,977.9	17,487.9	108.9%	
	ХАЦЭХ-ний тариф	төг/кВт*ц	221.9	254.21	271.45	17.2	106.8%	
	Хангах, түгээх үйл ажиллагааны зардал	сая төг	39,283.7	49,309.8	46,658.8	(2,651.0)	94.6%	
	Импортын эрчим хүчний зардал	сая төг	634.3	1,095.7	988.8	(107.0)	90.2%	
	Үйл ажиллагааны бус зардал	сая төг	1,725.4	1,547.7	3,275.6	1,727.9	211.6%	
	ҮХЭ-ийн зардал	сая төг	9,922.8	10,544.6	10,168.5	(376.1)	96.4%	
		Татвар төлөхийн өмнөх ашиг, алдагдал	сая төг	604.4	12.0	(7,578.1)	(7,590.1)	0.0%
4	Үндсэн үйл ажиллагааны ашиг, алдагдал	сая төг	43.7	0.0	(6,922.0)	(6,922.0)	0.0%	
	Импортын эрчим хүчний ашиг, алдагдал	сая төг	260.9	0.0	82.9	82.9	0.0%	
	Үйл ажиллагааны бус ашиг, алдагдал	сая төг	299.8	12.0	(739.0)	(751.0)	0.0%	
	Орлогын албан татвар	сая төг	306.9	-	(276.4)	(276.4)	0.0%	
	Татварын дараах ашиг, алдагдал	сая төг	297.6	12.0	(7,301.7)	(7,313.7)	0.0%	
6	Борлуулалтын төгрөгт ногдох зардал ¹	төг	1.0	1.00	1.03	0.0	103.0%	
	Нийт авлага	сая төг	2,730.8	1,534.1	3,008.3	1,474.2	196.1%	
7	Үүнээс: Хэрэглэгчээс авах ЦЭХ-ний авлага	сая төг	2,606.6	1,534.1	1,336.4	(197.7)	87.1%	
	Шөнийн тариф, өвлийн хүлэмжийн авлага	сая төг		-				
	Харилцагч байгууллагаас авах авлага	сая төг		-	64.7	64.7	0.0%	
	Урьдчилж төлсөн зардал	сая төг		-	7.7	7.7	0.0%	
	НӨАТ-ын авлага	сая төг		-	1,074.4	1,074.4	0.0%	
	Хэрэгжээгүй НӨАТ-ын авлага	сая төг	5.8	-	20.4	20.4	0.0%	
	ААНОАТ-ын авлага	сая төг		-	469.5	469.5	0.0%	
	Бусад авлага	сая төг	118.4	-	35.2	35.2	0.0%	
		Нийт өр төлбөр	сая төг	49,996.3	48,694.9	53,136.1	4,441.2	109.1%
	Урт хугацаат өр төлбөр	сая төг	42133.6	48,694.9	39,883.2	(8,811.7)	81.9%	
	Богино хугацаат өр төлбөр	сая төг	7862.6	-	13,252.9	13,252.9	0.0%	
8	Үүнээс: НХА-ийн өглөг	сая төг	2881.6	-	4,818.7	4,818.7	0.0%	
	БН-ийн өглөг	сая төг		-	211.2	211.2	0.0%	
	Татварын өглөг	сая төг		-	2.1	2.1	0.0%	
	ЦЭХ-ний УОО	сая төг	497.5	-	963.4	963.4	0.0%	
	Урт хугацаат тайлант үеийн өглөг	сая төг	3,448.7	0	3,448.7	3,448.7	0.0%	
	Хүүгийн өглөг	сая төг		-	264.9	264.9	0.0%	
	Бусад өглөг	сая төг	1,034.9	-	9.5	9.5	0.0%	
		Нийт ажиллагсдын тоо	хүн	530.5	564	544	(20.0)	96.5%

Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

10	Нийт цалингийн сан	сая төг	19498.7	25,168.5	24,044.2	(1,124.3)	95.5%
	Нэг ажилтны дундаж цалин /сарын/	төг	3,062,936.1	3,718,751	3,681,549	(37,202.0)	99.0%
11	Цахилгаан тасалдлын дундаж хугацаа Исайди	мин	808.7	800.0	719.0	(81.0)	89.9%
12	Хөрөнгө оруулалт, их засвар, ТЗБАХ	сая төг	5902.1	7,170.5	6,622.9	(547.6)	92.4%
	Үүнээс: Хөрөнгө оруулалт	сая төг	2699.1	2,606.9	2,202.9	(404.0)	84.5%
	Их засвар	сая төг	515.7	1,403.4	1,379.6	(23.8)	98.3%
	ТЗБАХ	сая төг	2687.4	3,160.2	3,040.4	(119.8)	96.2%

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Компани, түүний үйл ажиллагаа

Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх ТӨХК нь тайлант онд түгээх үйл ажиллагааны хувьд *“Шугам, тоноглолын шинэчлэлийн нэгдсэн бодлогыг хэрэгжүүлж, түгээх сүлжээний найдвартай ажиллагааг сайжруулах”*, хангах үйл ажиллагааны хувьд *“Өсөн нэмэгдэж буй хэрэглэгчдэд ухаалаг технологид суурилсан шуурхай, хүртээмжтэй, иж бүрэн үйлчилгээг үзүүлэх”* гэсэн хоёр зорилгыг 2024-2030 онд хэрэгжүүлэхээр тодорхойлжээ.

Тус компани нь ашиглалт үйлчилгээний заагаар хойд тал нь Хэнтий аймгийн Дадал сумаас урд тал нь Дорноговь аймгийн Ханги хилийн боомт хүртэл, зүүн тал нь Сүхбаатар аймгийн Түмэнцогт сумаас, баруун тал нь Дундговь аймгийн Дэлгэрхангай сум хүртэл, нийт 276.6 мянган км² газар нутаг дахь Нийслэлийн Багануур дүүрэг, Хэнтий, Говьсүмбэр, Дорноговь, Дундговь аймгуудын төв, суурин газрын нутаг дэвсгэрт байрлах 59.1 мянга гаруй хэрэглэгчдэд дараах чиглэлүүдийн дагуу үйл ажиллагаа явуулж байна. Үүнд:

- Цахилгаан түгээх;
- Цахилгаанаар зохицуулалттай хангах;
- БНХАУ-аас цахилгаан импортлох;
- Монгол улсад ашиглахыг зөвшөөрсөн загварын цахилгааны тоолуур, гүйдлийн трансформатор суурилуулах, засварлах;
- 0.4-220 кв-ын цахилгаан дамжуулах шугам, дэд станцын угсралт, засварын ажил, түүний туршилт тохируулгын ажил үйлчилгээ.
- Эрчим хүчний барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах

Тус компани нь дээрх зургаан тусгай зөвшөөрлийн эрх үүргийн хүрээнд түгээх, хангах үйл ажиллагааны чиглэлээр Диспетчерийн үндэсний төв ХХК-иас 787.7 сая.кВт.цаг цахилгаан эрчим хүчийг худалдан авч, 748.0 сая.кВт.цаг цахилгаан эрчим хүчийг хэрэглэгчдэд түгээн борлуулж байна.

Цахилгаан дамжуулах 0.4–220 кВ-ын агаарын шугам, дэд станцын засвар, угсралт, түүний туршилт тохируулга, дагалдах ажил үйлчилгээний тусгай зөвшөөрлийн эрх үүргийн хэмжээнд 0.4-110 кВ-ын хүчдэлийн 46 дэд станц, 523 трансформаторын дэд өртөө, 4462.8 км цахилгаан дамжуулах агаарын шугам, 170.3 км кабель шугамын ашиглалт, засварын ажлыг хариуцан ажиллаж байна. Цахилгаан импортлох тусгай зөвшөөрлийн эрх үүргийн хүрээнд Дорноговь аймгийн Ханги хилийн боомтоор 3.0 сая.кВт*ц цахилгаан эрчим хүчийг импортоор худалдан авч байна.

Бүтэц, зохион байгуулалтын хувьд Эрчим хүчний сайдын 2025 оны А/249 дүгээр тушаалаар баталсан бүтэц, зохион байгуулалтын дагуу 5 салбар, 7 хэлтэс, 5 алба, нийт 565 ажилтантайгаар ажиллахаас 544 орон тоотойгоор компанийн чиг үүргийг хэрэгжүүлсэн байна.

3.2 Компанийн гадаад, дотоод орчин

Тайлант онд Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2025 оны төсвийн тухай;
- Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
- Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай;
- Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
- Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай;
- Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 05 албан даалгавар “Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай”;

Компанийн удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

Эрчим хүчний яамнаас дотоод аудитыг хэрэгжүүлдэг ба тайлант онд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгдээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт бүрэн тохирсон гэж үнэлж байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх “Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлтэй холбогдолтой хууль, журам, бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 0.2 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/сая төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	3,176.9	1,895.7	(1,281.2)
Авлага	2,723.9	3,000.6	276.7
Урьдчилж төлсөн тооцоо	6.9	7.7	0.8
Бараа материал	2,331.1	2,152.0	(179.1)
Эргэлтийн бус хөрөнгө	179,261.6	180,054.4	792.9
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	187,500.3	187,110.4	(389.9)
Богино хугацаат өр төлбөр	7,862.6	13,252.9	5,390.2
Урт хугацаат өр төлбөр	42,133.6	39,883.2	(2,250.4)
Өр төлбөрийн нийт дүн	49,996.3	53,136.1	3,139.8
Эздийн өмчийн дүн	137,504.0	133,974.3	(3,529.7)
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	187,500.3	187,110.4	(389.9)

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө, авлага, урьдчилж төлсөн тооцоо, бараа материал, хөрөнгө, өр төлбөр, эздийн өмч данснуудад өөрчлөлт гарсан байна. Үүнд:

Тайлант онд мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө 1,895.7 сая төгрөг болж 1,281.2 сая төгрөгөөр буурсан нь Эрчим хүчний зохицуулах хорооноос мөнгөний урсгалын буцах санхүүжилтийн хувийг 2025 оны 1-р улиралд 50.5% байсныг 2-р улиралд 16.7%, 3-р улиралд 16.2%, 4-р улиралд 7.2% болгож бууруулсан нь шууд нөлөөлжээ. Тайлант онд бэлэн мөнгөний 5.8 сая төгрөгийн, харилцах дансны 1,889.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Авлага өмнөх оноос 276.7 сая төгрөгөөр нэмэгдэж 3,000.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан нь цахилгаан эрчим хүчний авлага 1,263.5 сая төгрөгөөр, бэлтгэн нийлүүлэгчээс авах авлага 14.6 сая төгрөгөөр тус тус буурч, татварын авлага 1,521.6 сая төгрөгөөр, бусад авлага 33.4 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэнээс шалтгаалсан байна. Авлагын үлдэгдэлд хэрэглэгчээс авах ЦЭХ-ний авлага 1,407.7 сая төгрөг, ААНОАТ-ын авлага 469.5 сая төгрөг, хувь тэнцүүлсэн НӨАТ-ын авлага 1,074.4 сая төгрөг, бусад авлага 11.8 сая төгрөг байна.

Урьдчилж төлсөн зардал 0.8 сая төгрөгөөр нэмэгдэж 7.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан нь диспетчерийн үндэсний төвийн үйлчилгээний төлбөрийн илүү төлөлт 2.5 сая төгрөгөөр нэмэгдэж 7.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. УБДС ТӨХК-иас дамжуулан алдагдал бууруулах төслийн зээлийн хүүгийн авлага 205.9 мянган төгрөгөөр буурч 131.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Бараа материал данс 179.1 сая төгрөгөөр буурч 2,152.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан нь Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн гүйцэтгэх захирлын шийдвэрээр аюулгүйн нөөцийн сэлбэгийг зохистой зөв болгох, ашиглаж болох бараа материалаар засварын ажлыг гүйцэтгэж шаардлагагүй худалдан авалтыг хийхгүй байх чиглэл өгсөнтэй холбоотой байна.

Эргэлтийн бус хөрөнгө 180,054.4 сая төгрөг болж 792.9 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд хөрөнгө оруулалт, их засвар, ТЗБАХ-ний ажлын 6,622.9 сая төгрөг,

ТӨБЗГ-ын 2024 оны 673, 2025 оны 272, 661, 673 дугаар тогтоол, А/1043 дугаар албан бичгийн дагуу 4,994.0 сая төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, ТӨБЗГ-ын 695, Засгийн газрын 91, 190 дугаар тогтоолоор 467.3 сая төгрөгийн хөрөнгө хасагдсан байна.

Богино хугацаат өр төлбөр өмнөх оноос 5,390.2 сая төгрөгөөр нэмэгдэж 13,252.9 сая төгрөгөөр тайланд тусгагдсан. Үүнд: Татварын өр 704.1 сая төгрөгөөр буурч, Нэг худалдан авагчийн өглөг 1,937.1 сая төгрөгөөр, “Эрчим хүчний төсөл-2”-ын зээлийн өглөг 3,534.4 сая төгрөгөөр, бэлтгэн нийлүүлэгчийн өглөг 90.2 сая төгрөгөөр, хүүгийн өглөг 57.2 сая төгрөгөөр, урьдчилж орсон орлого 465.9 сая төгрөгөөр, бусад богино хугацаат өр 9.5 сая төгрөгөөр тус тус өссөн байна.

- Дансны өглөг 2,027.4 сая төгрөгөөр нэмэгдэж, 5,029.9 сая төгрөгийн,
- Татварын өр 704.1 сая төгрөгөөр буурч, 2.1 сая төгрөгийн,
- Хүүгийн өглөг 57.2 сая төгрөгөөр нэмэгдэж, 264.9 сая төгрөгийн,
- Урт хугацаат өрийн тайлант үеийн өглөг 3,534.4 сая төгрөгөөр нэмэгдэж 6,983.1 сая төгрөгийн,
- Бусад богино хугацаат өр төлбөр 9.5 сая төгрөгөөр нэмэгдэж 9.5 сая төгрөгийн,
- Урьдчилж орсон орлого 465.9 сая төгрөгөөр нэмэгдэж, 963.4 сая төгрөгийн өр төлбөртэй тусгагдсан.

ЦЭХ-ний урьдчилж төлсөн орлого салбараар:

- Компани - 623.4 сая төгрөг,
- Багануур салбар - 165.3 сая төгрөг,
- Дорноговь салбар - 13.0 сая төгрөг,
- Дундговь салбар - 8.3 сая төгрөг,
- Хэнтий салбар - 9.6 сая төгрөг,
- Говьсүмбэр салбар -143.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Урт хугацаат өр төлбөр өмнөх оноос 2,250.4 сая төгрөгөөр буурч 39,883.2 сая төгрөгийн дүнтэй тайланд тусгагдсан. Урт хугацаат өр төлбөр буурсан нь “Эрчим хүчний төсөл-2” зээлийн 2026 онд төлөгдөх хуваарийн 1,008.0 мянган доллар буюу 3,585.1 сая төгрөг богино хугацаат өр төлбөрт шилжсэнтэй холбоотой буурч, гадаад валютын ханшийн зөрүүнээс 1,453.0 сая төгрөгөөр нэмэгдсэн, УБДС ТӨХК-иар дамжуулан авсан 1492-MON (SF) зээлийн 2026 оны хуваарьт төлөлтийн 1.1 сая төгрөгийн зээл богино хугацаат өр төлбөрт шилжүүлсэнтэй холбоотой байна.

Эзэмшигчийн өмчийн дүн 3,529.7 сая төгрөгөөр буурч, 133,974.3 сая төгрөгөөр тайланд тусгасан нь дүрмийн сан буюу өмч 3,102.2 сая төгрөгөөр, эздийн өмчийн бусад хэсгийн дүн 726.2 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл 23.1 сая төгрөгөөр, хуримтлагдсан ашиг 7,335.0 сая төгрөгөөр тус тус буурснаас шалтгаалжээ.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Эрчим хүчний Сайдын 2025 оны А/21, А/249 дүгээр тушаалаар Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна.

Тайлант оны нийт орлогыг 247,455.2 сая төгрөгөөр, нийт зардлыг 247,443.2 сая төгрөгөөр, 12.0 сая төгрөгийн ашигтай ажиллахаар тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 7,170.5 сая төгрөгийг төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 256,323.0 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 263,901.1 сая төгрөгийн зардал гарган, 276.4 сая төгрөгийн татвар тайлагнаж татварын дараах 7,301.7 сая төгрөгийн алдагдалтай тайлагнасан байна. Зардал нэмэгдэж, алдагдалтай болсон нь Эрчим хүчний зохицуулах хорооны 2025 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 648 дугаар тогтоолоор худалдан авах цахилгаан эрчим хүчний тарифыг 268.95 төг/кВт.цаг байсныг 39.08 төг/кВт.цагаар нэмэгдүүлж 308.03 төг/кВт.цаг болгосонтой холбоотой ХАЦЭХ-ний зардал 8.9 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь шууд нөлөөлсөн байна.

2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөний 12 үзүүлэлтийг 100 хувиар биелүүлж ажилласан байна. Үүнд:

- **Зорилт 1:** Тайлант хугацаанд худалдан авсан цахилгаан эрчим хүчний төлөвлөгөөг 15.4 сая кВт*ц-аар илүү буюу 101.9 хувиар, түгээлтийн алдагдлыг 0.4 хувиар бууруулж 5.0 хувьтай, хэрэглэгчдэд борлуулах цахилгаан эрчим хүчний төлөвлөгөөг 17.8 сая кВт*ц-аар илүү буюу 102.4 хувиар тус тус биелүүлсэн.
- **Зорилт 2:** Нийт орлогын төлөвлөгөөг 8,867.8 тэрбум төгрөгөөр илүү буюу 103.8 хувиар биелүүлсэн.
- **Зорилт 3:** Нийт зардал төлөвлөгөөнөөс 16,457.9 сая төгрөгөөр илүү буюу 6.6 хувиар хэтэрсэн. Үүнд: Худалдан авсан ЦЭХ-ний зардал төлөвлөгөөнөөс 17,487.9 сая төгрөгөөр, үйл ажиллагааны бус зардал (гадаад валютын ханшийн бодит бус алдагдал) 1,727.9 сая төгрөгөөр тус тус хэтэрч, хангах, түгээх үйл ажиллагааны зардал 2,651.0 сая төгрөгөөр, импортын ЦЭХ-ний зардлыг 107.0 сая төгрөгөөр тус тус хэмнэсэн.
- **Зорилт 4,5:** Татварын өмнөх (7,578.1) сая төгрөгийн, татварын дараах (7,301.7) сая төгрөгийн тус тус алдагдалтай ажиллаж, төлөвлөгөөнөөс 7,313.7 сая. төгрөгөөр нэмэгдсэн нь Эрчим хүчний зохицуулах хорооны 2025 оны 10 сарын 29-ний өдрийн 648 дугаар тогтоолоор худалдан авах цахилгаан эрчим хүчний тариф буюу үнийг 268.95 төг/кВт.цаг байсныг 39.08 төг/кВт.цагаар нэмэгдүүлж 308.03 төг/кВт.цаг болгосонтой холбоотой ХАЦЭХ-ний зардал 8.9 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь шууд нөлөөлсөн байна.
- **Зорилт 6:** Борлуулалтын нэгжид ногдох зардлыг төлөвлөгөөнөөс 0.03 сая төгрөгөөр нэмэгдсэн. (ЭХЗХ-ний 2025 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 648 дугаар тогтоолоор худалдаж авах ЦЭХ-ний үнийг 268.95 төг/кВт.ц гэснийг 308.03 төг/кВт.ц болгож 39.08 төг/кВт.ц-аар нэмэгдүүлсэн)
- **Зорилт 7:** Нийт 3,008.3 сая төгрөгийн авлагатай, зорилтоос 1,474.2 сая төгрөгөөр нэмэгдсэн. Мөн Эрчим хүчний зохицуулах хорооны 2025 оны 10 сарын 29-ний өдрийн 648 дугаар тогтоолоор худалдан авах цахилгаан эрчим хүчний тариф буюу үнийг 268.95 төг/кВт.цаг байсныг 39.08 төг/кВт.цагаар нэмэгдүүлж 308.03 төг/кВт.цаг болгосонтой холбоотой ХАЦЭХ-ний зардал 8.9 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь 1,543.9 сая төгрөгийн татварын авлага үүсэхэд нөлөөлсөн. ЦЭХ-ний 1.407.7 сая төгрөг нь зөвхөн Багануур Дулааны Станц ТӨХК-иас авах авлага үлдсэн.
- **Зорилт 8:** Нийт 53,136.1 сая төгрөгийн өглөгтэй, үүнээс урт хугацаат өр төлбөр 39,883.2 сая төгрөгийн, богино хугацаат өр төлбөр 13,252.9 сая төгрөгийн тус тус өглөгтэй, зорилтоос 4,441.2 сая төгрөгөөр нэмэгдсэн. Сангийн яамны хуваарийн дагуу Дэлхийн банкны “Эрчим хүч-2” төслийн зээл

болон хүүгийн төлбөрийг санхүүгийн тайланд богино хугацаат өр төлбөр дансны урт хугацаат өрийн тайлант үеийн өглөг дансанд бүртгэсэн, мөн ЭХЗХ-ноос мөнгөний урсгалын коэффициентийг оны сүүлээр өөрчилсөнтэй холбоотойгоор нэг худалдан авагчийн өр төлбөр өссөн.

- **Зорилт 9:** Компанийн хэмжээнд нийт 565 орон тоо батлагдсанаас Ханги хилийн боомтын шуурхай үйлчилгээ, засварын монторын орон тоог импортын зардалд шилжүүлж тооцооноор нийт 564 орон тоотой ажиллахаас гүйцэтгэлээр 544 орон тоотой ажиллаж байна.
- **Зорилт 10:** Нийт цалингийн сангийн зардалд 25,168.5 сая төгрөг төлөвлөснөөс гүйцэтгэлээр 24,044.2 сая төгрөгийн зардалтай ажиллаж, төлөвлөгөөнөөс 1,124.3 сая төгрөгөөр хэмнэсэн.
- **Зорилт 11:** Тайлант хугацаанд нэг хэрэглэгчид ногдож буй тасалдлын үргэлжлэх дундаж хугацаа Исайди-719 минут буюу 81 минутаар буурсан.
- **Зорилт 12:** Их засвар, техник зохион байгуулалтын арга хэмжээ, хөрөнгө оруулалтын нийт 120 нэр төрлийн, 7,170.5 сая төгрөгийн ажил батлагдсан. Гүйцэтгэлээр 6,622.9 сая төгрөгөөр 120 нэр төрлийн ажлыг бүрэн 100 хувь хийж, 547.6 сая төгрөгийн хэмнэлттэй ажилласан.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн нягтлан бодох бүртгэл болон хууль тогтоомжтой холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Санхүүгийн аудитын албаны ахлах аудитор М.Ундармаа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Отгонбаяр, санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер Х.Түвшинбаяр, тэргүүлэх аудитор Г.Нандинжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК нь 2025 оны санхүүгийн тайланг Нийслэл дэх Төрийн аудитын газарт 2026 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн 10/109 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлыг тооцох эх сурвалжийг 2025 оны орлогын дэлгэрэнгүй тайлан, суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2025 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардал 192,890.8 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 1,928.9 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус байгууллага нь хангах, түгээх үйл ажиллагааны зардалд нийт 29 нэр төрлийн, 49,309.8 сая төгрөгийн зардал төлөвлөснөөс гүйцэтгэлээр 29 нэр төрлийн, 46,658.8 сая төгрөгийн зардалтай ажиллаж, 2,651.0 сая төгрөгийг хэмнэсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 4 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 24 төрлийн 431,791.4 мянган төгрөгийн 1272 мэдээллийг Шилэн дансны цахим системд ил тод байршуулсан эсэхийг шалгахад бүрэн байршуулахаас 3,622.2 сая төгрөгийн 127 мэдээллийг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-т “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;” гэж заасантай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим системд цалингаас бусад орлого, зарлагын гүйлгээг хуулийн хугацаанд мэдээлж хэвших зөвлөмж өгөв.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Шаардлага хангахгүй 809.5 сая төгрөгийн анхан шатны баримтаар тендерийн баримт бичиг, хурлын тэмдэглэл, үнэлгээ болон гэрээг баталгаажуулсан байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйл. “Худалдан авах ажиллагааны зарчим”, 11 дүгээр зүйл. “Тендер шалгаруулалтын баримт бичиг” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тендер шалгаруулалтын бүх үе шатанд баримт бичгийн бүрдлийг бүрэн хангаагүй тохиолдолд аливаа шийдвэр гаргах, гэрээ байгуулах үйл ажиллагааг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага өгөв.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2025 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд хийсэн завсрын аудитаар нягтлан бодох бүртгэл

болон хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой нийт 668.4 сая төгрөгийн 11 зөрчил илэрч шалгагдагч байгууллагад танилцуулсан. Завсрын аудитаар өгсөн шийдвэрийн хэрэгжилтийг шалгахад 4 зөвлөмжийг хэрэгжүүлж, 7 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй тул аудитын илрүүлэлтэд тусгалаа.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар 1,759.8 сая төгрөгийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал болон хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой 9 зөрчил илэрснээс 27.2 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 556.4 сая төгрөгийн 4 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 1,176.1 сая төгрөгийн 4 зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж өгснийг 100.0 хувь хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	27,234.0	1	27,234.0	100
Албан шаардлага	4	556,435.5	4	556,435.5	100
Зөвлөмж	4	1,176,144.9	4	1,176,144.9	100
Нийт дүн	9	1,759,814.4	9	1,759,814.4	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татах асуудал гараагүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 748.0 сая төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 6.9 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт, 128.1 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 613.1 сая төгрөгийн зөрчилд 6 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

5.1.1 Эрчим хүчний баярт 2.8 сая төгрөгийг зарцуулахаар эрх бүхий албан тушаалтны тушаал гарсан боловч 9.3 сая төгрөг зарцуулж, 6.5 сая төгрөгийг хэтрүүлсэн нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5-д “Төрийн өөрийн өмчийг зориулалт бусаар захиран зарцуулах, нийгмийн шинжтэй төсөл, арга хэмжээнд зарцуулах, хандив, тусламж, түүнтэй адилтгах хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхийг хориглох бөгөөд энэхүү хориглолтыг зөрчсөн эрх бүхий этгээдийг албан тушаалаас чөлөөлж, учруулсан хохирлыг нөхөн төлүүлнэ”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.7-д “аливаа үйл ажиллагааны зохион байгуулалт нь өртөг зардлын бодит тооцоолол, баталсан стандарт, хэрэгцээ, шаардлагад үндэслэгдсэн байх”, 12 дугаар зүйлийн 12.1.4-д “хуулиар зөвшөөрөөгүй бусад”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-д “хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх”, гэж заасантай тус тус нийцээгүй санхүүгийн тайлагналын “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

¹Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Шийдвэрлэсэн нь: Зориулалт бусаар зарцуулсан 6.5 сая төгрөгийг буруутай албан тушаалтнаар төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.1.2 Хувь хүний буруу үйлдлээс болж эвдэрсэн машины 0.4 сая төгрөгийн үнэлгээг компанийн хөрөнгөөр хийлгэсэн нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5-д “Төрийн өөрийн өмчийг зориулалт бусаар захиран зарцуулах, нийгмийн шинжтэй төсөл, арга хэмжээнд зарцуулах, хандив, тусламж, түүнтэй адилтгах хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхийг хориглох бөгөөд энэхүү хориглолтыг зөрчсөн эрх бүхий этгээдийг албан тушаалаас чөлөөлж, учруулсан хохирлыг нөхөн төлүүлнэ”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-д “хуулиар зөвшөөрөөгүй бусад”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-д “хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх” гэж заасантай тус тус нийцээгүй санхүүгийн тайлагналын “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зориулалт бусаар зарцуулсан 0.4 сая төгрөгийг буруутай албан тушаалтнаар төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

5.2.1 Салбаруудын төлөвлөгөөнд тусгагдаагүй зардал буюу зар сурталчилгааны зардалд 99.8 сая төгрөг зарцуулсан нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3-д “үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах”, 20.1.7-д “тогтоосон журмын дагуу анхан шатны бүртгэлийг хөтөлж нягтлан бодох бүртгэлийн тайлан тэнцэл, статистикийн мэдээ гаргах ажлыг зохион байгуулж, тэдгээрийн үнэн зөвийг хариуцах”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэж заасантай тус тус нийцээгүй санхүүгийн тайлагналын “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлөвлөгөөнд тусгагдаагүй зар сурталчилгааны зардал гаргасан зөрчлийг зогсоож, давтан гаргахгүй ажиллах албан шаардлага өгөв.

5.2.2 Худалдан авах ажиллагаанд мөрдөх босго үнийг баримталж ажиллаагүй 28.3 сая төгрөгийн шууд худалдан авалт хийсэн нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т “Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно” заалт, Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн “Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай” 02 дугаар тогтоолтой тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Босго үнийн шаардлагыг мөрдөж ажиллаагүй шууд худалдан авалт хийсэн зөрчлийг зогсоож, давтан гаргахгүй ажиллах албан шаардлага өгөв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хөрөнгө, бараа материалын данстай холбоотой

Илрүүлэлт-1: Ажилтан, албан хаагчдын ашиглаж байгаа эд хариуцагчийн картыг шинэчлээгүй, хөрөнгийн коджуулалтыг дутуу хийсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлагналын "иж бүрэн байх" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Ажилтан, албан хаагчдад хариуцуулан ашиглуулж буй хөрөнгийн эд хариуцагчийн картыг шинэчлэн бүрэн гүйцэд хөтлөх, хөрөнгийн коджуулалтыг нэгдсэн журмын дагуу иж бүрэн хийж, бүртгэл, хяналтыг сайжруулах;

Илрүүлэлт-2: Аюулгүйн нөөц материалын үлдэгдэлд батлагдсан нэр төрлөөс өөр 105 нэр төрлийн бараа материал бүртгэлтэй байгаа нь Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн гүйцэтгэх захирлын "Заавар шинэчлэн батлах тухай" А/36 дугаар тушаалын долоодугаар хавсралттай нийцээгүй, санхүүгийн тайлагналын "үнэлгээ ба хуваарилалт" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Аюулгүйн нөөцийг стандартын дагуу бүрдүүлж, хангуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх;

Илрүүлэлт-3: Ашиглалтын дэвтэрт баяжуулалт хийгээгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх" , 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын "иж бүрэн байх" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хөрөнгийн ашиглалтын дэвтрийн мэдээллийг бүрэн гүйцэд баяжуулж, тухай бүр шинэчлэн хөтөлж, нягтлан бодох бүртгэлийн үнэн зөв, иж бүрэн байдлыг хангаж ажиллах;

2. Зардлын данстай холбоотой:

Илрүүлэлт-1: Хөрөнгө зарцуулах тушаал шийдвэргүйгээр сургалтад цай, кофе зэргийг худалдан авсан нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5 "Хариуцлагатай байх" 6 дугаар зүйлийн 6.4.1-т "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"; 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын "нийцсэн бөгөөд зохистой" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Тушаал шийдвэргүйгээр хөрөнгө зарцуулахгүй байх;

Илрүүлэлт-2: Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай албан даалгаврыг хэрэгжүүлж ажиллаагүй, тэвчиж болох 291.8 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн нь Монгол улсын ерөнхий сайдын 05 дугаар албан даалгавартай нийцээгүй, санхүүгийн тайлагналын "нийцсэн бөгөөд зохистой" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Цаг үеийн шинжтэй гарсан холбогдох хууль тогтоомжийг мөрдөн ажиллах;

Дээрх аудитын шийдвэрийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 09 дүгээр сарын 30 ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчил

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс:					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Дүн	Тоо
Эрчим хүчний баярт 2.8 сая төгрөгийг зарцуулахаар эрх бүхий албан тушаалтны тушаал гарсан боловч 9.3 сая төгрөг зарцуулсан. (Говьсүмбэр салбар)	1	6,532.0	1	6,532.0				
Хувь хүний буруу үйлдлээс болж эвдэрсэн машины үнэлгээг компанийн хөрөнгөөр хийлгэсэн. (Говьсүмбэр салбар)	1	390.0	1	390.0				
Салбарын төлөвлөгөөнд тусгагдаагүй зардал буюу зар сурталчилгааны зардалд 99.8 сая төгрөг зарцуулсан.	1	99,800.0			1	99,800.0		
Худалдан авах ажиллагаанд мөрдөх босго үнийг баримталж ажиллаагүй шууд худалдан авалт хийсэн.	1	28,250.0			1	28,250.0		
2025 оны хөрөнгийг ажилтан, албан хаагчдын ашиглаж байгаа эд хариуцагчийн картыг шинэчлээгүй, хөрөнгийн коджуулалтыг дутуу хийсэн.	1	-					1	-
Батлагдсан аюулгүй байдлын нэр төрлөөс өөр 105 нэр төрлийн бараа материал бүртгэлтэй байна.	1	171,946.8					1	171,946.8
Бараа материалын тайланг дансны нэр төрлөөр гаргаагүй, бараа материалыг шууд зардлаар бүртгэсэн. (Говьсүмбэр салбар)	1	148,314.7					1	148,314.7
Ашиглалтын дэвтэрт баяжуулалт хийгээгүй. (Говьсүмбэр салбар)	1	-					1	-

Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Хөрөнгө зарцуулах тушаал шийдвэргүйгээр сургалтад цай, кофе зэргийг худалдан авсан. (Говьсүмбэр салбар)	1	983.8					1	983.8
Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай албан даалгаврыг хэрэгжүүлж ажиллаагүй, тэвчиж болох зардлыг санхүүжүүлсэн байна.	1	291,807.9					1	291,807.9
Дүн	10	748,025.2	2	6,922.0	2	128,050.0	6	613,053.2

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс:			
	Тоо	Дүн	Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Дүн	Тоо
Төндөрийн баримт бичиг, хурлын тэмдэглэл, үнэлгээ болон гэрээг шаардлага хангахгүй анхан шатны баримтаар баталгаажуулсан байна.	1	809,467.3	1	809,467.3		
Шилэн дансанд 127 мэдээллийг оруулаагүй.	1	3,622,200.2			1	3,622,200.2
Дүн	2	4,431,667.5	1	809,467.3	1	3,622,200.2

